



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 04 өдөр

Дугаар A/57

Мандалговь

“Дэлгэрцогт, Эрдэнэдалай, Сайхан-Овоо суманд мал угаалгын ванн шинээр барих ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Дэлгэрцогт, Эрдэнэдалай, Сайхан-Овоо суманд мал угаалгын ванн шинээр барих ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Түвшинбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Ө.Дугармаа (Төсөл хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Х.Отгонбаяр (Иргэний төлөөлөл)

Д.Энхтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Ё.Дашням (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Түвшинбаяр)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ө.Дугармаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

438190130